

Жишиг асуулт Барилгын салбарын 2-р зэргийн тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Барилгын практик ур чадвар)

Асуулт 1

Орон сууцны хана, шал, тоосго болон блокыг өрөх үеийн наалдуулах материал зэрэгт ашиглагддаг бөгөөд цементэд ус, элс хольж бэлтгэдэг барилгын материалыг юу гэдэг вэ?

1. Зуурмаг
2. Гипс
3. Бетон
4. Хатуу хөөс

Хариулт: 1

Асуулт 2

Хэвний ажилд ашигладаг "дугуй тусгаарлагч" нь юуг бүрэн хангахад зориулагдсан элемент вэ?

1. Бетоны бат бэх байдал
2. Шалны арматурын хучилтын зузаан
3. Бетоны зузаан
4. Хэвний бат бэх байдал

Хариулт : 3

Асуулт 3

Голчлон ханын суурь материал болгон ашигладаг бөгөөд гол гипсний хоёр тал болон хажуу талыг хавтангийн зориулалттай цаасаар бүрсэн барилгын хавтан материалыг юу гэдэг вэ?

1. Гипсэн хавтан
2. Ханын обой
3. Шалны винил хавтан
4. Панел хэв

Хариулт: 1

Асуулт 4

Багананд арматур зангидахад нээлхийг бэхжүүлэх зорилгоор суурилуулдаг зүйлийг юу гэдэг вэ?

1. Хэмжээ шалгах тууз
2. Боловсруулсан зургийн шошго
3. Жийргэвч блок
4. Бүс арматур

Хариулт : 4

Асуулт 5

Япон маягийн өрөөнүүдийг тусгаарлах үед ашигладаг, модон рамд цаас нааж, ирмэг, бариул гаргасан зүйлийг юу гэдэг вэ?

1. Хүрээтэй хаалга
2. Шахмал хаалга
3. Гүйдэг хаалга
4. Цонхны хүрээ

Хариулт: 3

Асуулт 6

Будгийн ажлын талаарх буруу бичвэрийг сонгоно уу.

1. Бороотой үед ч ажлыг явуулна.
2. Суурь түрхэлт хийхийн өмнө тоос шороо, бохирыг арилгана.
3. Будгийг хатах хүртэл хангалттай цаг байлгана.
4. Суурь, дунд, өнгөн түрхэлт гэсэн 3 үе шатаар хувааж хийнэ.

Хариулт: 1

Асуулт 7

Шат ашиглах ажилтай холбоотой бичвэрээс зөвийг нь сонгоно уу.

1. Шат дээр дамнаж зогсож ажиллана.
2. Шатны дээд тавцан дээр зогсоно.
3. Хоёр гартаа ачаа барьж өгсөнө.
4. Шатны нэг талд зогсож ажиллана.

Хариулт : 4